



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2015 оны 12 сарын 24 өдөр

Дугаар A-200

Улаанбаатар хот

Г Банкны санхүүгийн тайлан, бусад мэдээллийг⁷
олон нийтэд мэдээлэх загвар маягт батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх заалт, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.3 дахь заалт, “Банкны зохицой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Банкны санхүүгийн тайлан, бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх загвар маягтыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаалыг мөрдөж ажиллахыг банкуудын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

3.Монголбанкны Ерөнхийлөгчийн 2003 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 371 дүгээр тушаалыг 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганбат)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Н ЗОЛЖАРГАЛ



Монголбанкны Ерөнхийлөгчийн
2015 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн
1200 дугаар тушаалтын хавсралт



БАНКНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, БУСАД МЭДЭЭЛЛИЙН
ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ ЗАГВАР МАЯГТ

Aгуулга	Маягтын дугаар
Хувьцаа эзэмшигчдийн ил тод байдал	Маягт 1
Банкны эрх бүхий албан тушаалтны ил тод байдал	Маягт 2
Санхүүгийн хураангуй тайлан	Маягт 3
Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт	Маягт 4
Орлогын тайлан	Маягт 5
Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайлан	Маягт 6
Банкны ажлын тайлан /жилийн тайлан/	Маягт 7
Банкны үйл ажиллагааны ил тод байдал	Маягт 8




ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Банкны тухай хуулийн 38.2.2, 38.2.4, 38.2.7 дахь заалт, "Банкны зохицтой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам"-ын 8.1 дэх заалтын дагуу хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнийг шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор доорх загварт нийцүүлэн олон нийтэд мэдээлнэ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнийг Загвар 1-т үзүүлсэн жишээ аргыг ашиглан харуулах бөгөөд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн овог нэр, тэдгээрийн эзэмшиж буй хувийг тус тус тусгаж харуулна. Хэрвээ хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч (компанийн нийт хувьцааны тав ба түүнээс дээши хувийг дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа этгээд) хүртэл задалж харуулна.

Загвар-1 /Жишээ/



- Банкны хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол тус хуулийн этгээдийн нөлөө бүхий хувь эзэмшигчдийн мэдээллийг Загвар 2-ын дагуу олон нийтэд мэдээлнэ. Үүнд:

Загвар2 /Жишээ/

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Хуулийн этгээдийн үйл ажиллагааны төрөл	Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн овог, нэр	Тухайн хуулийн этгээдийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн эзэмшигчдийн нөлөө бүхий хувь хэмжээ
1.	Хуулийн этгээдийн нэр	Гадаад худалдаа	Овог, нэр	50%
			Овог, нэр	50%
2.	Хуулийн этгээдийн нэр	Санхүүгийн бизнес	Овог, нэр	100%



БАНКНЫ ЭРХ БУХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Банкны тухай хуулийн 38.2.4 дэх заалт, "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам"-ын 8.1 дэх заалтын дагуу банкны эрх бүхий албан тушаалтны мэдээллийг шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор доорх загварт нийцүүлэн олон нийтэд мэдээлнэ. Үүнд:

- 1) ТҮЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах зарчим, гишүүдийн хараат бус байдлыг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд, их хэмжээний болон ашиг сонирхлын зөрчилтэй хэлцлийг хэрхэн хянаж, зөвшөөрөл олгодог талаар.
- 2) ТҮЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, эрх үүрэг, тайлагналын тогтолцооны талаар.
- 3) Банкны ТҮЗ-ийн гишүүдийн нэрс, мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага туршлага, эзэмшсэн боловсрол, банкны хувьцаа эзэмшигч эсэх мэдээлэл. Банкны ТҮЗ-ийн гишүүн нь тухайн банкны гүйцэтгэх удирдлагад давхар ажилладаг эсэх мэдээлэл.
- 4) Банкны бусад эрх бүхий албан тушаалтны нэр, мэргэжлийн ур чадвар, ажлын туршлага, боловсрол болон харьяалагдаж буй нэгжийн эрх үүргийн талаар.
- 5) Банкны зүгээс ТҮЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын талаар баримтлах бодлого.

Банкны санхүүгийн тайлан, бусад мэдээллийг
олон нийтэд мэдээлэх загвар маягт 3

САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Банкны тухай хуулийн 38.1 дэх заалтын дагуу банк, түүний толгой компани, тэдгээрийн хараат, охин компани, банкны нэгдлийн улирлын санхүүгийн тайланг тус тус дараа сарын дотор, жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа оны нэгдүгээр улиралд багтаан доорх загварт нийцүүлэн олон нийтэд мэдээлнэ. Үүнд:

Он/сар/өдөр

Балансын зүйл		Хугацааны эхний үлдэгдэл	Хугацааны эцсийн үлдэгдэл
1.	ХӨРӨНГӨ		
1.1.	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	-
1.2.	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	-	-
1.3.	Хөрөнгө оруулалт	-	-
1.3.1.	Хараат, хамтын хяналттай, охин компанийд оруулсан хөрөнгө оруулалт		
1.4.	Зээл (цэвэр дүнгээр)	-	-
1.4.1.	Хэвийн зээл		
1.4.2.	Чанаргүй зээл*		
1.4.3.	Зээлийн хойшлогдсон төлбөр		
1.4.4.	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага		
1.4.5.	Зээлийн эрсдэлийн сан		
1.5.	Дериватив санхүүгийн хөрөнгө		
1.6.	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.7.	Бусад санхүүгийн бус хөрөнгө	-	-
1.8.	Үндсэн хөрөнгө		
1.9.	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.10.	Борлуулах зориулалттай хөрөнгө		
1.11.	Биет бус хөрөнгө		
1.12.	Нийт хөрөнгийн дүн	-	-
2.	ӨР ТӨЛБӨР		
2.1.	Харилцах	-	-
2.2.	Хадгаламж		
2.3.	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	-	-
2.4.	Бусад эх үүсвэр	-	-
2.5.	Бусад өр төлбөр**		
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
3.	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
3.1.	Хувь нийлүүлсэн хөрөнгө	-	-

3.2.	Нэмж төлөгдсөн капитал		
3.3.	Халаасны хувьцаа		
3.4.	Дахин үнэлгээний нэмэгдэл		
3.5.	Хуримтлагдсан ашиг, алдагдал		
3.6.	Бусад өөрийн хөрөнгө	-	-
3.7.	Өөрийн хөрөнгийн дүн	-	-
4.	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	-	-

Тэнцлийн гадуурх данс

Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг (цэвэр дүнгээр)***

* - Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээлийн нийлбэр дүн

** - Бусад өр төлбөр гэдэгт Дериватив санхүүгийн өр төлбөр, Бусад санхүүгийн өр төлбөр, Бусад санхүүгийн бус өр төлбөр, Хоёрдогч өглөг, Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)-г тайлагнана.

*** - Харилцагчийн нэрийн өмнөөс гаргасан эх үүсвэргүй баталгаа, батлан даалт, нээсэн зээлийн шугам, аккредитив гэх зэрэг бусдын өмнөөс хүлээж болзошгүй үүрэг

ооо



МОНГОЛБАНКНААС ТОГТООСОН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

Банкны тухай хуулийн 38.2.7 дахь заалтын дагуу Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн улирлын биелэлтийг дараа сарын дотор доорх загварт нийцүүлэн олон нийтэд мэдээлнэ. Үүнд:

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт*	Байвал зохих	Биелэлт
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	9%	
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	12% (14%**)	
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	25%	
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	15%	
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	40%	

* - VaR эрхийг Монголбанкнаас авсан банк хүснэгтэд VaR гэж бичнэ.

** - Системийн нөлөө бүхий банкинд тавигдах шаардлага

оOо

Банкны санхүүгийн тайлан, бусад мэдээллийг
олон нийтэд мэдээлэх загвар маягт 5



БАНКНЫ ОРЛОГЫН ТАЙЛАН

Банкны тухай хуулийн 38.1 дэх заалтын дагуу банк, түүний толгой компани, тэдгээрийн хараат, охин компани, банкны нэгдлийн улирлын орлогын тайланг тус тус дараа сарын дотор, жилийн эцсийн орлогын тайланг дараа оны нэгдүгээр улиралд багтаан доорх загварт нийцүүлэн олон нийтэд мэдээлнэ. Үүнд:

Он/сар/өдөр (сая төгрөгөөр)

Орлого, зардлын зүйл		Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
1.	Хүүгийн орлого		
1.1.	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн		
1.2.	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн		
1.3.	Үнэт цаасны		
1.4.	Зээлийн		
1.5.	Бусад хүүгийн орлого		
2.	Хүүгийн зардал		
2.1.	Харилцахад төлсөн хүү		
2.2.	Хадгаламжинд төлсөн хүү		
2.3.	Зээлийн хүүгийн зардал		
2.4.	Үнэт цаасны хүүгийн зардал		
2.5.	Бусад хүүгийн зардал		
3.	Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]		
4.	Эрсдэлийн сангийн зардал		
5.	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]		
6.	Бусад орлого		
6.1.	Хүүгийн бус орлого		
6.1.1.	Арилжааны орлого		
6.1.2.	Ханш, үнэлгээний тэгшигтгэлийн орлого		
6.1.3.	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого		
6.1.4.	Бусад хүүгийн бус орлого		
6.2.	Бусад орлого, олз		
7.	Бусад зардал		
7.1.	Хүүгийн бус зардал		
7.1.1.	Бусад эрсдэлийн сангийн зардал		
7.1.2.	Арилжааны зардал		
7.1.3.	Ханш, үнэлгээний тэгшигтгэлийн зардал		
7.1.4.	Хураамж, шимтгэлийн зардал		
7.1.5.	Үйл ажиллагааны бусад зардал		
7.2.	Бусад зардал, гарз		
8.	Татварын өмнөх ашиг, алдагдал [(5)+(6)-(7)]		

9.	Орлогын татварын зардал		
10.	Татварын дараах ашиг, алдагдал [(8)-(9)]		
11.	Бусад орлого		
12.	Тайлант хугацааны нийт орлогын дүн [(10)+(11)]		

**БАНКНЫ ХОЛБОГДОХ ЭТГЭЭД (НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД)-Д
ОЛГОСОН ЗЭЭЛ БОЛОН ЗЭЭЛТЭЙ АДИЛГАН ТООЦОХ БУСАД АКТИВ
ХӨРӨНГИЙН ТАЙЛАН**

Банкны тухай хуулийн 38.2.6 дахь заалт, "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам"-ын 8.1 дэх заалтын дагуу банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн улирлын тайланг дараа сарын дотор доорх загварт нийцүүлэн олон нийтэд мэдээлнэ. Үүнд:

Он/сар/өдөр (сая төгрөгөөр)

Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)	Активын хэлбэр	Үлдэгдэл дүн	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
1. Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй)			
1.1. Банкны хувьцаа эзэмшигч*			
1.2. Банкны эрх бүхий албан тушаалтан*			
1.3. Банкны бусад холбогдох этгээд*			
2. Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй)			
2.1. Банкны нийт хувьцаа эзэмшигчид			
2.2. Банкны эрх бүхий албан тушаалтнууд			
2.3. Банкны бусад холбогдох этгээд			

* - Банкны холбогдох нэг этгээд (Банкны хувьцаа эзэмшигч, банкны эрх бүхий албан тушаалтан, эсвэл банкны бусад холбогдох этгээд)-эд олгосон хамгийн өндөр дунтэй зээл болон зээлтэй адилтган тооцох актив хөрөнгийн дунг тайлагнана.

БАНКНЫ АЖЛЫН ТАЙЛАН /ЖИЛИЙН ТАЙЛАН/

Банкны тухай хуулийн 38.1, 38.2.1 дэх заалт, "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам"-ын 8.1 дэх заалтыг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлагын гарын үсгээр баталгаажуулсан үйл ажиллагааны жилийн тайланг доорх загварт нийцүүлэн дараа оны нэгдүгээр улиралд багтаан олон нийтэд мэдээлнэ. Үүнд:

- 1) Банкны товч танилцуулга /эрхэм зорилго, хэтийн зорилт, эрхэмлэх зүйлс/.
- 2) Харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг, харилцагчдын эрх ашгийг хамгаалах талаар баримтлах бодлогын хэрэгжилт.
- 3) Банкны толгой компани, тэдгээрийн хараат болон охин компанийн засаглалын талаар баримтлах зарчим, бодлогын хэрэгжилт.
- 4) Удирдлагын ёс зүйн талаар баримтлах бодлого болон банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилт.
- 5) Бизнесийн үйл ажиллагааны онцлох үзүүлэлтүүдийн өөрчлөлт болон тайлбар.
- 6) Банкны тухай хуулийн 37.2-т заасан шаардлагыг хангасан санхүүгийн жилийн тайлан, гол өөрчлөлтүүдийн тайлбар
- 7) Банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны тайлан.
- 8) Мэдээллийн технологиын үйл ажиллагааны тайлан.
- 9) Хүний нөөцийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт.
- 10) Гадаад болон дотоодын салбар нэгжийн тоо, байршил, үйл ажиллагааны талаарх мэдээлэл.
- 11) Компанийн нийгмийн хариуцлага, Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилт.
- 12) Сонирхлын зөрчилтэй хэлцлийн үнийн дүн, тоон үзүүлэлтийн тайлан болон холбогдох тайлбар.

БАНКНЫ САНХҮҮ, БҮРТГЭЛИЙН ТОГТОЛЦОО, ДОТООД ХЯНАЛТ

Банкны тухай хуулийн 38.2.3 дахь заалтын дагуу банкны санхүү, бүртгэл, дотоод хяналтын тогтолцооны тухай мэдээллийг шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор доорх загварт нийцүүлэн олон нийтэд мэдээлнэ. Үүнд:

- 1) Санхүүгийн тайлан мэдээг боловсруулах үйл ажиллагаа, хариуцсан алба нэгжийн тухай.
- 2) Санхүүгийн тайлан мэдээг боловсруулах үйл ажиллагаанд тавигдах давхар болон дараалсан хяналтын тогтолцоо.
- 3) Банкны удирдлагад тайлагнах тайлагналын тогтолцоо, баталгаажуулалт, давтамжийн талаарх мэдээлэл.



Банкны санхүүгийн гайлан, бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх загвар маягт 8

БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

"Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам"-ын 8.1 дэх заалтын дагуу банкны үндсэн үйл ажиллагааны мэдээллийг шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор доорх загварт нийцүүлэн олон нийтэд мэдээлнэ.

Банкны удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны талаарх танилцуулга. Үүнд:

- 1) Банкны удирдлага зохион байгуулалтын бүтэц, эрх зүйн хэлбэр, байршил.
- 2) Банкны эрхлэх үйл ажиллагааны төрөл.
- 3) Банкны тусгай зөвшөөрөл.
- 4) Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү, шимтгэл, хураамжийн талаарх мэдээлэл.

ооо